


1.гэдэг нь нийгмийн тодорхой хэрэгцээг хангахад чиглэсэн үүрэг, статусын цогц. Зөв хариултыг сонгоорой. /1 оноо/
 - a. Нийгмийн институт b. Нийгмийн харилцаа c. Нийгмийн бүтэц d. Нийгмийн хандлага e. Нийгмийн тогтолцоо
2. Шинэ мэдлэг бүтээх, мэдлэгийг хойч үедээ дамжуулах, өсвөр үеийг нийгэмшүүлэх, боловсон хүчнийг бэлтгэх нь нийгмийн аль институтын үүрэг вэ? /1 оноо/
 - a. Шашны b. Гэр бүлийн c. Улс төрийн d. Эдийн засгийн e. Боловсролын
3. Сонгуульд оролцож, саналаа өгөхийн төлөө тэмцэж байсан эмэгтэйчүүдийг дорд үзэж, улмаар хорих, шийтгэх, янз бүрийн нэр хоч өгч байсан нь өнөөгийн ардчиллын өнцгөөс харвал хэм хэмжээг зөрчсөн үйлдлийн ямар төрөлд хамаарагдахыг олж тэмдэглэ. /3 оноо/
 - a. Гэмт хэрэг b. Нийгмийн хяналт c. Нийгмийн гажуудал d. Албан бус хяналт e. Албан ёсны хяналт
4. Нийгмийг амьд биетэй төстэй хэмээн үзэж, эд эрхтэн нь тухайн амьд биеийг амьдруулахын төлөө үүрэг гүйцэтгэж байдгийн адил нийгмийн институт нь нийгмийн болон бусад институтын төлөө тодорхой үүрэг гүйцэтгэдэг гэсэн онол аль нь вэ? /1 оноо/
 - a. Шалтгаант чанарын онол b. Бүтэц чиг үүргийн онол c. Харилцан үйлдлийн онол d. Зөрчилдөөний онол e. Нийгмийн онол
5. Нийгмийн амьдралд үндсэн эргэлт гаргадаг, харьцангуй хурдтай, чанарын гүнзгий өөрчлөлтийг юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/
 - a. Хувьсгал b. Хувьсал c. Шинэчлэл d. Дэвшил e. Ухралт
6. Нийгмийн хэв маягуудыг дурдахдаа илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? /1 оноо/
 - a. Аж үйлдвэржсэн нийгэм b. Гар урлалын нийгэм c. Газар тариалангийн нийгэм d. Мал аж ахуйн нийгэм e. Аж үйлдвэржсэний дараах нийгэм
7. Нийгмийн давхраажилтын хэв маягуудад аль нь хамааралгүй вэ? /1 оноо/
 - a. Каст b. Боолчлол c. Язгуур d. Эд баялаг e. Анги
8. Нийгмийн давхраажилтын Марксист онолын суурь ойлголтуудаас илүүц зүйл дурдсан бол аль нь вэ? /1 оноо/
 - a. Анги b. Статус c. Нэр хүнд d. Эрх мэдэл e. Эд баялаг
9. Нийгмийн давхраажилтын талаар М.Веберийн онолын суурь ойлголтуудаас илүүц зүйл дурдсан бол аль нь вэ? /2 оноо/
 - a. Эд баялаг b. Нэр хүнд c. Хүсэл тэмүүлэл d. Эрх мэдэл e. Хөрөнгө мөнгө
10. Боловсролын түвшнээс хамааралгүйгээр нийгмийн бүх хүмүүст хүртээмжтэй байдаг соёлын хэлбэрийг олж тэмдэглэнэ үү? /1 оноо/
 - a. Гадны соёл b. Элитийн соёл c. Ардын соёл d. Дагуул соёл e. Нийтийн соёл
11. “Соёлын үнэт зүйл гэдэгт эх хэл, бичиг үсэг, уламжлалт технологи, газар усны нэр, зан заншил, бэлгэ тэмдэг, ном судар, шашдир болон соёл судлалын бүтээл хамаарна” гэж ямар хуульд заасан бэ? /2 оноо/
 - a. Монгол улсын Соёлын тухай хуульд b. Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд c. Монгол улсын Хөдөлмөрийн хуульд d. Монгол улсын Боловсролын хуульд e. Монгол улсын Үндсэн хуульд
12. Соёлыг илрэх байдлаар нь хэрхэн ангилдаг вэ? /1 оноо/
 - a. Эртний болон орчин үеийн соёл b. Эдийн болон оюуны соёл c. Соёлын хямрал түрэмгийлэл d. Соёлын даяаршил, зөрчил e. Соёлын нэгдэл, хуримтлал
13. Соёлын босоо чиглэлийн ангилалд илүүц зүйл дурдсан бол аль нь вэ? /1 оноо/
 - a. Зонхилогч соёл b. Элитийн соёл c. Ардын соёл d. Нийтийн соёл e. Соёлын эрх чөлөө
14. Тухайн хүний оюуны өмчөөр хамгаалагдсан соёлын агуулга бүхий бараа бүтээгдэхүүн, түүний үйлдвэрлэл хуваарилалт, нийлүүлэлтийн тогтолцоог.....гэнэ. /1 оноо/
 - a. Соёлын үйлдвэрлэл b. Соёлын дархлаа c. Соёл судлал d. Соёлын бүтээгдэхүүн e. Соёлын менежмент
15. Соёлын үйлдвэрлэлийг нэрлэхдээ илүүц зүйл дурдсан бол аль нь вэ? /3 оноо/
 - a. Соёлд суурилсан бүтээлч үйлдвэрлэл b. Бүтээлч, шинэ эдийн засаг c. Утаагүй үйлдвэрлэл d. Соёлын орон зай e. Чөлөөт цагт зориулсан үйлдвэрлэл /шоу бизнес/
16. Өнөө үеийн ардчилсан, нээлттэй гадаад харилцааны үндсэн дээр тусгаар соёлууд дэлхийн нэгдмэл соёлд нэгдэн нийлэх үйл явцыг юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/
 - a. Соёлын гадуурхал b. Уламжлалт соёл c. Соёлын даяаршил d. Дэд соёл e. Хэлний соёл
17. Оюуны соёлд хамаарахгүй зүйлийг олоорой. /1 оноо/
 - a. Урлаг b. Хувцас c. Шинжлэх ухаан d. Ёс суртахуун e. Ном шашдир
18. Соёлын эрх чөлөөний асуудалд хамааралгүй зүйл аль нь вэ? /1 оноо/
 - a. Амьдралын хэв маягийг үгүйсгэх b. Бүх хүмүүс эх хэлээрээ ярьж, өөрийн шашныг шүтэж, өөрийн бүтээн туурвих бололцоог эдлэх эрх c. Хүмүүс өөрсдийгөө илэрхийлэх, өөрийн хувийн чанараа хөгжүүлэх d. Баталгаат боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ e. Олон төрлийн нийгмийн баталгаагаар хангагдаж байх эрх
19. ДНБ-ийг тогтмол үнээр тооцсоныг юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/
 - a. Байнгын b. Нэрлэсэн ДНБ c. Бодит ДНБ d. Тогтмол e. Зах зээлийн
20. ДНБ зардлаар тооцогдоо хамааралгүй зүйлийг олоорой. /1 оноо/
 - a. Хувь хүний хэрэглээний зардал b. Өрх гэрийн хэрэглээний зардал c. Аж ахуйн нэгжийн зардал d. Төрийн зардал e. Гадаад хэрэглэгчийн зардал
21. Ямар нэг компанийн өмчийн тодорхой хэсгийг эзэмшиж буйг гэрчилсэн баримтыггэнэ. /1 оноо/
 - a. Бонд b. Хувьцаа c. Хадгаламж d. Үнэт цаас e. Лиценз
22. Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор улсын орлого, зарлагыг өөрчлөх бодлогыг ямар бодлого гэдэг вэ? /1 оноо/
 - a. Төрийн сангийн буюу төсвийн бодлого b. Төрийн мөнгө зээлийн бодлого c. Эдийн засгийн бодлого d. Засгийн газрын бодлого e. Төрийн бодлого
23. Өндөр хурдтай инфляцийн үед хэн хожиж болох вэ? /2 оноо/
 - a. Зээлээ төлж байгаа хүмүүс b. Үндсэн хөрөнгөө худалдаж байгаа хүмүүс c. Үндсэн хөрөнгө худалдан авч байгаа хүмүүс d. Банкинд хадгаламжтай хүмүүс e. Тэтгэвэр, тэтгэмж авч байгаа хүмүүс

Элсэлтийн ерөнхий шалгалт -2019 он

24. Гүйлгээнээс мөнгө татах буюу мөнгөний нийлүүлэлтийг бууруулах бодлогыг ямар бодлого гэдэг вэ? /1 оноо/
a. Эдийн засгийн b. Мөнгөний тэлэх c. Засгийн газрын d. Сангийн яамны e. Мөнгөний хумих
25. Доор дурдсан шийдвэрүүдээс аль нь инфляцийн эсрэг бодлогод хамаарах вэ? /3 оноо/
a. Банкны зээлийн хүүг бууруулах b. Засгийн газраас бонд гаргаж худалдах c. Банкинд байгаа хадгаламжуудыг индексжүүлэх d. Татварын хувь хэмжээг өсгөх e. Мөнгөний нийлүүлэлтийг нэмэх
26. Экспорт, импортын зөрүүг.....гэнэ. /1 оноо/
a. Гадаадын хандив тусламж b. Гадаадын хөрөнгө оруулалт c. Гадаад худалдааны ашиг d. Гадаад худалдааны алдагдал e. Гадаад худалдааны тэнцэл
27. Эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтүүдэд хамааралгүйг олно уу? /1 оноо/
a. Ажилгүйдэл, ядуурал буурсан b. Амьжиргааны түвшин дээшилж, эдийн засаг өссөн c. Үйлдвэрлэлийн салбар хумигдаж, эдийн засгийн бүтээмж буурсан d. Эдийн засаг тогтвортой өссөн e. Чадварлаг, бүтээлч иргэд
28. Ардчилсан нийгэм бүх иргэдэд адил тэгш боломж олгодог онцлогтой. Энэ нь хэн нэгнийг илүү харж, эрх дарх олгохгүй гэсэн үг юм. Энэ нь ардчилалын аль зарчим бэ? /2 оноо/
a. Нээлттэй байх зарчим b. Шударга байх зарчим c. Хууль дээдлэх зарчим d. Цөөнхийг хүндэтгэх зарчим e. Зөвшилцлийн зарчим
29. Хууль тогтоох засаглал буюу парламент, шүүх-арми гэсэн бүтэцтэй гүйцэтгэх засаглал, хаан сайд нар багтдаг байгууллага буюу холбооны засаглалын ангилал хийсэн сэтгэгчийг нэрлэнэ үү? /1 оноо/
a. К.Маркс b. Ш.Монтескье c. Н.Макиавелли d. Ж.Локк e. М.Вебер
30. Чөлөөт нийгэм дэх иргэний нийгмийн гол үүрэг нь аль вэ? /1 оноо/
a. Ард түмэн төрд үг дуугүй үнэнч байх b. Эрх чөлөөт байдлыг хангах c. Хувь хүмүүс мөр мөрөө хөөх явдал d. Төрийг хянаж, төрд хариуцлага хүлээлгэх e. Сонгуульд идэвхтэй оролцох
31. Иргэний нийгмийн үндсэн шинжид аль нь хамаарахгүй вэ? /1 оноо/
a. Иргэдийн нийгмийн идэвх дээшлэх b. Хүний эрх, эрх чөлөөг дээдлэх c. Зах зээлийн эрүүл саруул тогтолцоог хөгжүүлэх d. Мэдээллийн хэрэгслийн эрх чөлөө e. Нийгмийн бүх асуудлууд төрийн оролцоотойгоор шийдвэрлэх
32. Иргэн хүн сонгуульд оролцох нь нийгмийн аль хүрээний харилцаанд хамаарагдах вэ? /1 оноо/
a. Улс төрийн хүрээ b. Социаль хүрээ c. Эдийн засгийн хүрээ d. Хүмүүнлэгийн хүрээ e. Оюун санааны хүрээ
33. Намын нэрээр санал хурааж авсан саналд нь хувь тэнцүүлж суудал хуваарилдаг сонгуулийн тогтолцоо аль нь вэ? /1 оноо/
a. Мажоритар b. Холимог c. Чөлөөт сонгууль d. Пропорциональ e. Уламжлалт
34. Ардчилсан нийгэмд хэвлэл мэдээлэл нь ард түмэнд үнэн зөв мэдээлэл хүргэхэд дараах зарчмуудыг мөрдөнө. Хамааралгүй зүйл оруулсан бол аль нь вэ? /1 оноо/
a. Нэг хүний эрх ашгийн төлөө бус олон түмний тусын тулд үнэн зөв мэдээлэл дамжуулах b. Намын ажлаа тайлагнах c. Нас хүйс, шашин шүтлэг, боловсролын түвшинг харгалзахгүйгээр бүх нийтэд тэгш хүргэх боломжийг нь хуулиар хангах d. Ард түмний дуу хоолой болох e. Хэвлэл мэдээллийн ажилтнууд болон сэтгүүлчдийн эрх чөлөөг хамгаалах.
35. Ардчилсан нийгэмд хэвлэл мэдээллийн баримтлах зарчмуудыг тоочихдоо илүүц зүйл оруулсныг ялгаж тэмдэглэнэ үү? /3 оноо/
a. Олон түмний эрх ашгийн төлөө үнэн зөв мэдээлэл дамжуулах b. Улс төрийн аль нэг намын байр суурийг илэрхийлэгч байх c. Нас хүйс, шашин шүтлэг, боловсролын түвшинг харгалзахгүйгээр мэдээллийг бүх нийтэд тэгш хүргэх боломжийг нь хуулиар хангах d. Ард түмний дуу хоолой болох e. Хэвлэл мэдээллийн байр суурь
36. Д.Истоны улс төрийн системийн загварыг гүйцээнэ үү. /1 оноо/



- a. А. хувиргалт Б. эргэх холбоо В. шийдвэр Г. үйлдэл
b. А. эргэх холбоо Б. хувиргалт В. зөвшилцөл Г. үр дүн
c. А. хэлэлцээр Б. хувиргалт В. үр дүн Г. шийдвэр
d. А. үйлдэл Б. хувиргалт В. эргэх холбоо Г. зөвшилцөл
e. А. шийдвэр Б. эргэх холбоо В. үр дүн Г. хувиргалт
37. Хүний эрхэм чанарын үндсэн шинжүүдэд илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? /1 оноо/
a. Хүний эрхэм чанар хүн бүрт ялгаатай байх b. Хүний эрхэм чанар нь хүн бүрт адилхан байх c. Хүнээс хүний эрхэм чанарыг нь салгаж болохгүй d. Хүний эрхэм чанар нь халдаж болохгүй e. Хүний эрхэм чанар нь үл хэмжигдэх үнэт зүйл
38. Хүний эрхийн түгээмэл тунхаглал хэдэн онд батлагдсан бэ? /1 оноо/
a. 1990 b. 1954 c. 1946 d. 1957 e. 1948
39. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн хуульд зааснаар “тэтгэвэрийн даатгалын сангаас даатгуулагчид олгох тэтгэвэр нь:,, тэтгэвэр” гэсэн төрөлтэй байдаг. /1 оноо/

Элсэлтийн ерөнхий шалгалт -2019 он

- a. Ажилгүйдлийн, өндөр насны, тахир дутуугийн b. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсэний, өндөр насны c. Өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны d. Тэжээгчээ алдсаны, ажилгүйдлийн, жирэмсэний e. Оршуулгын, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны
40. Ажилгүйдлийн тэтгэмжийг ямар нөхцөлд олгодог вэ? /2 оноо/
- a. Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг ажилгүй болохоосоо өмнө 12 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 6 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд
b. Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг ажилгүй болохоосоо өмнө 18 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 6 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд
c. Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг ажилгүй болохоосоо өмнө 12 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 5 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд
d. Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг ажилгүй болохоосоо өмнө 24 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 6 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд
e. Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг ажилгүй болохоосоо өмнө 24 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 9 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд
41.нь зөвхөн Үндсэн хууль зөрчсөн талаар маргааныг шийдвэрлэж, хуульд заасан тодорхой байгууллага, албан тушаалтны шийдвэр үйл ажиллагаа үндсэн хуульд нийцэж байгаа эсэхэд хяналт тавьдаг. /2 оноо/
- a. УИХ b. Үндсэн хуулийн цэц c. Засгийн газар d. Намууд e. Шийдвэр гаргах түвшний албан тушаалтнууд
42. Иргэн А нь малаа бэлчээрт гаргахын тулд Б-тэй зөвшилцөн түүний газрыг хязгаартай ашиглах гэрээ байгуулж хоёр тал тохиролцсон. Хэсэг хугацааны дараа гэрээнд тусгагдсан зүйлүүд зөрчигдөж, иргэн Б ашиг орлогоо алдаж, өмч хөрөнгөнд нь хохирол учирсан. Энэ тохиолдолд иргэн Б ямар шатны шүүхэд нэхэмжлэл гаргах вэ? /1 оноо/
- a. Захиргааны хэргийн анхан шатны шүүх b. Иргэний хэргийн дунд шатны шүүх c. Иргэний хэргийн анхан шатны шүүх d. Захиргааны хэргийн дунд шатны шүүх e. Аймаг, нийслэлийн шүүх
43. Хуульд заасан гэм буруутай бүх үйлдэл, эс үйлдлийг эрх зүйн зөрчил гэж хэлдэг. Эрх зүйн зөрчлийг хэрхэн ангилдаг вэ? /1 оноо/
- a. Ёс суртахууны доройтол, гэмт үйлдэл b. Гэм хор, гэмт хэрэг c. Хохирол, хор уршиг d. Хор уршиг, гэм хор e. Гэмт хэргийн ба гэмт хэргийн бус
44. Гэм хорын тухай ойлголтуудыг зөв харгалзуулна уу? /3 оноо/
- | | | | |
|---|-----------|---|---|
| a | Гэм хор | 1 | Хохиролын улмаас үүссэн үр дагавар |
| b | Хохирол | 2 | Эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус гэж ангилна. |
| c | Хор уршиг | 3 | Эрх зүйн зөрчлийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, аюулгүй байдалд учирсан үр дагавар. |
- a. A1 B3 C2 b. A3 B2 C1 c. A3 B1 C2 d. A2 B3 C1 e. A2 B1 C3
45. Захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн оролцогч этгээдийг тоочихдоо илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? /1 оноо/
- a. Гомдол гаргаж буй иргэн ба хуулийн этгээд b. Дүүргийн засаг дарга c. Хариуцагч болох захиргааны байгууллага, албан тушаалтан d. Гуравдагч этгээд e. Туслах чиг үүрэгтэй оролцож буй этгээд
46. Аль нь захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах вэ? /3 оноо/
- a. Иргэн Ц нь өөрийг нь ямар ч үндэслэлгүйгээр төрийн албанаас халсан гэж үзээд b. Иргэн Э нь өөрийн эзэмшлийн PRUIS 30 маркын автомашиныг түрээсийн гэрээгээр Б-д шилжүүлэв. Гэтэл 1 сарын дараа Б нь автомашиныг осолд оруулж дахиж унах аргагүй болгожээ. Тэрээр өөрийн өмч хөрөнгөд халдсан гэж үзээд c. Зохиогчийн эрхийг зөрчиж бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, худалдсан, түгээсэн, улсын хилээр нэвтрүүлсний улмаас зохиогчид их хэмжээний хохирол учирсан бол d. Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар өөрийн мэдэлд шилжүүлэн авсан нь тогтоогдвол e. Төр нь хүний тодорхой эрхийг хүлээн зөвшөөрөөгүй бол
47. Монгол улсын гадаад бодлогын чиглэлд хамааралгүй зүйлийг тэмдэглэнэ үү? /1 оноо/
- a. Улс төр, дипломатын b. Эдийн засаг, бизнесийн c. Соёл, хүмүүнлэгийн d. Үзэл суртал, суртал нэвтрүүлгийн e. Шинжлэх ухаан, технологийн
48. НҮБ-ийн үндсэн зорилтуудыг нэрлэхдээ илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? /1 оноо/
- a. Үндэстэн, улс орнуудын хооронд найрсаг харилцааг хөгжүүлэх b. Дэлхий дахинд энх тайван аюулгүй байдлыг сахин хангах c. Гадаад худалдааг хөгжүүлж, ашиг олох d. Хүний эрх, эрх чөлөөг зөрчих явдалтай тэмцэх e. Бичиг үсэг үл мэдэх, өвчин эмгэг, өлсгөлөн ядуурлыг даван туулахад туслах
49. Монгол улсын гадаад бодлогын эн тэргүүний зорилтыг олно уу? /1 оноо/
- a. Посткоммунист орнуудтай харилцах b. Дэлхийн бүх орнуудтай харилцаж хамтын ажиллагаа өрнүүлэх c. Ази номхон далайн улс орнуудтай харилцах d. АНУ ба өрнөдийн хөгжингүй орнуудтай харилцах e. ОХУ, БНХАУ-тай найрсаг, сайн хөршийн хамтын ажиллагааг хөгжүүлэх
50. Боловсрол, шинжлэх ухаан, соёлын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилго бүхий НҮБ-ийн төрөлжсөн байгууллагыг нэрлэнэ үү? /1 оноо/
- a. ЮНИСЕФ b. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага c. ЮНЕСКО d. Хөгжлийн хөтөлбөр e. ЮНИДО
51. Монгол улсын гадаад бодлогын голлох бүс нутаг, улс орныг тоочихдоо илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? /2 оноо/
- a. Хойд Америк ба Европын улс орнууд b. Төв Африкийн улсууд c. Төв Азийн улс орнууд буюу тусгаар улсуудын хамтын нөхөрлөл d. Зүүн хойд Азийн бүс нутаг /ОХУ, БНХАУ, Солонгос, Япон г.м/ e. Зүүн өмнөд Азийн бүс нутаг
52. Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалд гадаад бодлогыг ямар төрлүүдэд ангилсан бэ? /2 оноо/
- a. Бүс нутгийн, олон улсын, тив дамнасан b. Улс төр, эдийн засаг, боловсрол, соёл, хүмүүнлэгийн c. Хоёр талын ба олон талт хамтын ажиллагааны d. Бүс нутгийн ба тив дамнасан e. Улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, соёл, хүмүүнлэгийн
53. Ард түмэн олон улсын харилцаанд яаж оролцдог вэ? /1 оноо/
- a. Хувийн шугамаар b. Гадаадад гарч ажиллаж амьдрах c. Гадаадын пүүс, компани, ААН-тэй гэрээ хэлэлцээр хийснээр d. Өөрийгөө төлөөлөх тодорхой байгууллагаар дамжуулан e. Хараар /хууль бусаар ажиллаж амьдрах/
54. Монгол улс гуравдагч хөрштэйгээ хэзээнээс дипломат харилцаа тогтоож ирснийг зөв холбоно уу? /3 оноо/
- | | | | |
|---|-----------------------------------|---|----------|
| a | Монгол улс ба АНУ-ын харилцаа | 1 | 1990 онд |
| b | Монгол улс ба Япон улсын харилцаа | 2 | 1987 онд |

Элсэлтийн ерөнхий шалгалт -2019 он

с	Монгол улс ба БНСУ-ын харилцаа	3	1972 онд
---	--------------------------------	---	----------

a. A3 B1 C2 b. A3 B2 C1 c. A2 B3 C1 d. A1 B3 C2 e. A2 B1 C3

55. Зөөлөн хүчний бодлогын төрлүүдээс хамааралгүй зүйлийг олно уу. /1 оноо/

a. Албадлага b. Сэтгэл татах чавдар c. Зорилгыг өөрчлөн чиглүүлэх d. Үнэмшил, тогтолцоо e. Үнэт зүйлс, соёл, төрийн бодлого

56. “Зөөлөн хүч”-ний төрлүүдийг дурдахдаа илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? /3 оноо/

a. Бизнес инноваци b. Соёл, боловсрол c. Цэргийн d. Дипломат гадаад бодлого e. Улс төрийн үнэт зүйл, институцын хөгжил

ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ ДААЛГАВАР

Санамж:

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож хариуг бөглөөрэй.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.

2.1 Нийгмийн гажуудлын тухай ойлголтуудыг зөв харгалзуулна уу? /5 оноо/

a	Нийгмийн гажуудал	1	Нийгмийн хуульчлан тогтоосон хэм хэмжээг ноцтойгоор зөрчиж, бусдад гэм хор, хор хохирол учруулсан үйлдэл, эс үйлдэл
b	Нийгмийн хяналт	2	Нийгэм, нийгмийн бүлгүүдийн олонх гишүүдийн хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ хүлээлттэй үл нийцэх төлөв
c	Албан бус хяналт	3	Гажуудлыг арилгах үүднээс нийгмийн гишүүдийн зүгээс гажуудагчийг шийтгэх, засан хүмүүжүүлэх арга хэмжээний цогц
d	Албан ёсны хяналт	4	Жижиг бүлгийн түвшинд албан бус хэм хэмжээ, хүлээлтийг зөрчсөн үйлдэл хийснийх нь төлөө дургүйцэх, шүүмжлэх зэргээр илрэх хяналт
e	Гэмт хэрэг	5	Албан ёсны хэм хэмжээг зөрчсөний төлөө сануулга өгөх, ажлаас нь халах, торгох, эрхийг нь хязгаарлах зэрэг албан ёсны үүрэг хүлээсэн байгууллагуудын хүчээр хэрэгждэг, зохих албадлагад тулгуурласан хяналт

2.2 Соёлын үйлдвэрлэлийн ойлголтуудыг зөв харгалзуулна уу? /5 оноо/

a	Соёлын үйлдвэрлэл	1	Соёл хоорондын харилцааны олон хэлбэрийг багтаасан өөр соёлын орчинтой биечлэн танилцах аялал
b	Соёлын аялал жуулчлал	2	Улс орнуудын хоорондын харилцаа солилцоо эрчимжиж хэл, соёл, техник технологийн нэгдэн нягтрах үйл явц эрчимтэй явагдаж уламжлалт амьдралын хэв маяг сэтгэлгээнд өөрчлөлт гарах үзэгдэл
c	Соёлын даяаршил	3	Соёлын үнэлэмжүүдийн харилцан нөлөөллөөр бий болж байдаг орчин
d	Соёлын тулгалт	4	Оюуны өмчөөр хамгаалагдсан, соёлын агуулга бүхий бараа, бүтээл үйлдвэрлэх, тэдгээрийн хуваарилалт нийлүүлэлтийн тогтолцоо
e	Соёлын орон зай	5	Бүтээсэн бүхнийг устгаж, хүнийг тэр зүйлээ дахин бүтээхгүй болтол нь айлган сүрдүүлэх үйл явц

2.3 Инфляцийн тухай ойлголтуудыг зөв харгалзуулна уу? /5 оноо/

a	Инфляци	1	Өргөн хэрэглээний бараа, үйлчилгээнээс бүрдсэн тодорхой тооны нэр төрлийн барааны жагсаалтын үнэ бөгөөд амжиргааны түвшний өөрчлөлтийг хэмжих, үнийн өөрчлөлтийг тооцох зориулалттай статистик ойлголт
b	Хүм амын хэрэглээний сагс	2	Худалдаж авсан бараа, үйлчлүүлсэн үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь
c	Хэрэглээний бараа үйлчилгээний жин	3	Тодорхой хугацааны завсар дахь үнийн нийт түвшний өөрчлөлтийг хувиар илэрхийлснийг
d	Хэрэглээний үнийн индекс	4	Эдийн засагт бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ ерөнхийдөө өсөж хүн амын худалдан авах чадвар буурах үзэгдэл
e	Инфляцийн түвшин	5	Хэрэглэгчийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр, төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт

2.4 Ардчиллын хэлбэрүүдийг зөв харгалзуулна уу? /5 оноо/

a	Шууд ардчилал	1	Иргэн хүн хуулиар баталгаажсан эрхийг эдэлж, хуулийг дээдлэх ёсон
b	Төлөөллийн ардчилал	2	Сонгуульд санал өгөх, нэр дэвшүүлэх, жагсаал цуглаан хийх, төрийн байгууллага албан тушаалтанд хандаж захидал бичих, санал хүсэлтээ гаргах
c	Ардчилал	3	Иргэд улс төрийн шийдвэр гаргах, хууль боловсруулах, үүрэг бүхий албан тушаалтныг сонгож, түүгээр дамжуулан засаглалыг хэрэгжүүлэх хэлбэр
d	Хуулийн засаглал	4	Ард түмнээс сонгогдсон, ард түмний төлөө, ард түмний өөрсдийнх нь засаглал
e	Иргэдийн улс төрийн оролцоо	5	Олон түмэн өөрөө өөрийгөө удирдах хэлбэр